



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯНХОНГОР АЙМГИЙН БОЛОВСРОЛ СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2020 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/167/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2021 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584, 99007576

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424, 99442140

Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Азбаяр

Утас: 99061429

Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3.Аудитын тайлан	12
3.1. Ерөнхий зүйл	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт	17
Залруулсан алдаа	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	17
Аудитын зөвлөмж	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал.....	18
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19





**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН БОЛОВСРОЛ
СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ц.ЭНХТӨР ТАНАА

2021.02.25 № 2/81
танай _____ -ны № _____ -т
Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Боловсрол соёл урлагийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Боловсрол соёл урлагийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

1. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 87,3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч болон Баянхонгор аймгийн Засаг даргын хооронд 2020 онд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх үүргийн биелэлтийг аймгийн Засаг даргад тайлагнаж ажилласан байна.

2021 А4 ТООТ

005020030

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	138,779,314.53	168,311,284.06
33	АВЛАГА	995,437.21	18,607,354.74
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	450,000.00	48,168.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	18,359,814.00
335	Бусад авлага	545,437.21	199,372.74
3351	Байгууллагаас авах авлага	545,437.21	199,372.74
35	БАРАА МАТЕРИАЛ	137,783,877.32	149,703,929.32
351	Түүхий эд материал	135,000.00	135,000.00
35110	Тусгай зориулалттай материал	135,000.00	135,000.00
354	Хангамжийн материал	137,648,877.32	149,568,929.32
35410	Бичиг хэргийн материал	1,277,110.00	1,952,510.00
35420	Аж ахуйн материал	134,494,131.32	146,543,783.32
35430	Сэлбэг хэрэгсэл	1,345,000.00	540,000.00
35470	Бусад хангамжийн материал	532,636.00	532,636.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	104,442,655.61	318,115,744.22
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	104,442,655.61	318,115,744.22
392	Биет хөрөнгө	49,247,405.60	95,445,827.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,267,100.00	8,267,100.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8,267,100.00	-8,267,100.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	55,005,075.00	97,605,075.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-55,005,075.00	-57,255,075.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	105,314,478.33	121,119,478.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	-80,849,438.04	-85,344,924.93
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,300,298.10	19,682,234.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,279,971.35	-16,025,085.64
39214	Бусад үндсэн хөрөнгө	31,706,566.00	32,890,566.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-14,510,429.94	-19,886,343.30
39217	Ном	2,565,902.50	2,659,902.50
393	Биет бус хөрөнгө	55,195,250.01	222,669,916.69
39301	Програм хангамж	2,154,000.00	6,104,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,892,749.99	-1,391,083.31
39303	Бусад биет бус хөрөнгө	54,934,000.00	217,957,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	243,221,970.14	486,427,028.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,374,700.18	00.18
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,374,700.18	00.18
413	Өглөг	5,374,700.18	00.18
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,374,700.18	00.18
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	237,847,269.96	486,427,028.10
51	Засгийн газрын хувь оролцоо	237,847,269.96	486,427,028.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	260,916,977.83	423,939,977.83
51101	Өмч: - төрийн	260,916,977.83	423,939,977.83
512	Хуримтлагдсан үр дүн	-40,892,425.01	44,664,333.13
51210	Өмнөх үеийн үр дүн	-40,892,425.01	-40,892,425.01
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	85,556,758.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,822,717.14	17,822,717.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	243,221,970.14	486,427,028.28



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан


Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,739,377,967.89	2,578,562,498.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,305,679.00	128,204,048.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,305,679.00	128,204,048.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,305,679.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,162,453.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,143,226.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,733,072,288.89	2,450,358,450.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,061,887,100.00	2,241,496,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,061,887,100.00	2,241,496,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	671,185,188.89	208,861,550.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	63,611,000.00	45,086,550.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	85,100,000.00	135,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	522,474,188.89	27,525,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	1,250,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,759,580,317.62	2,493,005,739.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,759,580,317.62	2,493,005,739.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,036,773,067.62	884,354,734.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,373,706.00	298,928,636.00
210101	Үндсэн цалин	240,273,706.00	298,928,636.00
210104	Урамшуулал	100,000.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,902,054.00	33,159,204.15
210201	Тэтгэврийн даатгал	25,144,454.00	22,341,478.15
210202	Тэтгэмжийн даатгал	1,189,500.00	2,784,440.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	951,700.00	2,227,674.00
210204	Ажилгүйдлийн даатгал	237,800.00	541,379.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,378,600.00	5,264,233.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,600,000.00	40,888,650.00
210302	Түлш, халаалт	00.00	1,288,650.00
210304	Байрны түрээс	39,600,000.00	39,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	92,060,655.00	104,225,266.00
210401	Бичиг хэрэг	13,015,338.00	3,342,800.00
210402	Тээвэр, шатахуун	8,554,150.00	5,798,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	407,500.00	395,470.00
210404	Ном, хэвлэл	18,000.00	63,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	45,600.00	2,290,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	70,020,067.00	6,731,148.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	85,604,048.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,666,810.00	3,142,000.00
210604	Урсгал засвар	2,666,810.00	3,142,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,789,500.00	00.00
210702	Дотоод албан томилолт	3,789,500.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	601,045,168.89	381,625,480.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	601,045,168.89	381,405,480.00

Баянхонгор аймгийн Боловсрол соёл урлагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	220,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,335,173.73	22,385,497.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	90,000.00	79,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,031,500.00	7,691,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,213,673.73	14,614,847.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,722,807,250.00	1,608,651,005.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,712,774,409.00	1,549,831,493.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	701,416,542.00	781,444,669.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,010,357,867.00	767,681,824.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	705,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,032,841.00	58,819,512.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,032,841.00	58,819,512.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-20,202,349.73	85,556,758.14
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-20,202,349.73	85,556,758.14

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,733,072,288.89	2,450,358,450.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,733,072,288.89	2,450,358,450.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,061,887,100.00	2,241,496,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,061,887,100.00	2,241,496,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	671,185,188.89	208,861,550.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	63,611,000.00	45,086,550.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	85,100,000.00	135,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	522,474,188.89	27,525,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	1,250,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,733,072,288.89	2,428,075,450.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,733,072,288.89	2,428,075,450.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,010,265,038.89	792,119,508.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,770,720.00	285,790,153.00
210101	Үндсэн цалин	177,697,220.00	210,667,261.00
210102	Нэмэгдэл	48,105,200.00	54,589,392.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,672,000.00	12,140,900.00
210104	Урамшуулал	2,296,300.00	8,392,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,734,500.00	36,986,605.15
210201	Тэтгэврийн даатгал	20,219,400.00	26,016,117.76
210202	Тэтгэмжийн даатгал	2,378,800.00	2,784,440.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,903,000.00	2,227,674.78
210204	Ажилгүйдлийн даатгал	475,800.00	541,379.21



Баянхонгор аймгийн Боловсрол соёл урлагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	4,757,500.00	5,416,993.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,683,100.00	46,263,350.00
210301	Гэрэл, цахилгаан	00.00	2,033,300.00
210302	Түлш, халаалт	00.00	1,857,950.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	864,000.00
210304	Байрны түрээс	30,683,100.00	41,508,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,859,830.00	23,705,270.00
210401	Бичиг хэрэг	832,000.00	530,700.00
210402	Тээвэр, шатахуун	2,598,780.00	2,668,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	641,500.00	581,270.00
210404	Ном, хэвлэл	171,200.00	128,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	767,750.00	19,270,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	848,600.00	525,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	3,789,500.00	00.00
210702	Дотоод албан томилолт	3,789,500.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	677,718,538.89	388,349,380.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	677,718,538.89	388,349,380.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,708,850.00	11,024,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	434,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,208,850.00	10,590,650.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,722,807,250.00	1,635,955,941.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,712,774,409.00	1,558,776,615.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	701,416,542.00	781,444,669.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,010,357,867.00	776,626,946.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	705,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,032,841.00	77,179,326.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,032,841.00	77,179,326.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	22,283,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	22,283,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	22,283,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	22,283,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	22,283,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-22,283,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	260,916,977.83	17,822,717.14	-40,892,425.01	00.00	237,847,269.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	260,916,977.83	17,822,717.14	-40,892,425.01	00.00	237,847,269.96
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	163,023,000.00	00.00	00.00	00.00	163,023,000.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	85,556,758.14	00.00	85,556,758.14
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	423,939,977.83	17,822,717.14	44,664,333.13	00.00	486,427,028.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		хэтрэлт (+), хэмнэлт (-)	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,241,570,700.00	2,186,212,333.15	-55,358,366.85	97.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,241,570,700.00	2,186,212,333.15	-55,358,366.85	97.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	628,625,800.00	627,435,718.15	-1,190,081.85	99.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,827,800.00	285,790,153.00	-37,647.00	99.99
210101	Үндсэн цалин	207,968,700.00	210,667,261.00	2,698,561.00	101.30
210102	Нэмэгдэл	56,794,500.00	54,589,392.00	-2,205,108.00	96.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,672,000.00	12,140,900.00	-531,100.00	95.81
210104	Урамшуулал	8,392,600.00	8,392,600.00	0.00	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,046,800.00	36,986,605.15	-1,060,194.85	97.21
210201	Тэтгэврийн даатгал	26,773,600.00	26,016,117.76	-757,482.24	97.17
210202	Тэтгэмжийн даатгал	2,818,300.00	2,784,440.08	-33,859.92	98.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,254,600.00	2,227,674.78	-26,925.22	98.81
210204	Ажилгүйдлийн даатгал	563,700.00	541,379.21	-22,320.79	96.04



Баянхонгор аймгийн Боловсрол соёл урлагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	5,636,600.00	5,416,993.32	-219,606.68	96.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,294,100.00	46,263,350.00	-30,750.00	99.93
210301	Гэрэл, цахилгаан	2,238,200.00	2,033,300.00	-204,900.00	90.85
210302	Түлш, халаалт	967,900.00	1,857,950.00	890,050.00	191.96
210303	Цэвэр, бохир ус	728,000.00	864,000.00	136,000.00	118.68
210304	Байрны түрээс	42,360,000.00	41,508,100.00	-851,900.00	97.99
2104	Хангамж, бараа материалын зардал	23,843,700.00	23,799,270.00	-44,430.00	99.81
210401	Бичиг хэрэг	533,700.00	530,700.00	-3,000.00	99.44
210402	Тээвэр, шатахуун	2,668,500.00	2,668,500.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	622,600.00	581,270.00	-41,330.00	93.36
210404	Ном, хэвлэл	222,400.00	222,400.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,270,800.00	19,270,800.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	525,700.00	525,600.00	-100.00	99.98
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	223,742,200.00	223,741,590.00	-610.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	223,742,200.00	223,741,590.00	-610.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10871200.00	10854750.00	-16,450.00	99.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	278,800.00	264,100.00	-14,700.00	94.73
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,592,400.00	10,590,650.00	-1,750.00	99.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1612944900.00	1558776615.00	-54,168,285.00	96.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,612,944,900.00	1,558,776,615.00	-54,168,285.00	96.64
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	819,670,100.00	781,444,669.00	-38,225,431.00	95.34
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	792,569,800.00	776,626,946.00	-15,942,854.00	97.99
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	705,000.00	705,000.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,241,570,700.00	2,186,212,333.15	-55,358,366.85	97.53
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,241,570,700.00	2,186,212,333.15	-55,358,366.85	97.53
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,241,570,700.00	2,186,212,333.15	-55,358,366.85	97.53
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	20.00	20.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	02.00	02.00	0.00	100.00



2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	208,861,550.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	208,861,550.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	186,966,790.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	180,096,790.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	180,096,790.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	6,870,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	6,870,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	21,894,760.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	21,894,760.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	208861550.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	208,861,550.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	45,086,550.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	135,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	27,525,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	1,250,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00



3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч Ц.Энхтөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 19-нөөс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтээ Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 сарын 30-ны өдрийн 1/727 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын үйл ажиллагааны чиглэлийг Боловсрол, соёл, урлагийн байгууллагуудад арга зүйн зөвлөгөө өгөх гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Боловсрол соёл урлагийн газарт дотоод хяналт болон шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт



зардлыг сонгож, эрсдэлийн төвшнийг “Их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын төвшнийг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын 2493005,7 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 49860,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын төвшнийг багасгах шаардлага гараагүй.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 486427,0 мянган төгрөг болж өмнөх оноос 243205,1 мянган төгрөгөөр буюу 2 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь авлага, бараа материал үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /мянган төгрөг/ 3=2-1
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	138,779.3	168,311.3	29,532.0
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	995.4	18,607.4	17,611.9
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	137,783.9	149,703.9	11,920.1
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	104,442.7	318,115.7	213,673.1
Үндсэн хөрөнгө	279,247.4	506,285.4	227,037.9
Хуримтлагдсан элэгдэл	(174,804.8)	(188,169.6)	(13,364.8)
Нийт хөрөнгө	243,222.0	486,427.0	243,205.1
Өр төлбөр	5,374.7	0.0	(5,374.7)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	237,847.3	486,427.0	248,579.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	243,222.0	486,427.0	243,205.1

Тухайн байгууллага нь өмнөх онд 995,4 мянган төгрөгийн авлагатай байсан бол тайлант онд 18607,4 мянган төгрөг болж 17611,9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Авлага өссөн шалтгаан нь хүүхэд харах үйлчилгээний 18359,8 мянган төгрөгийн санхүүжилтийг оны сүүлчээр буюу 2020.12.25-нд олгож, буцаан татсантай холбоотойгоор авлагаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 149703,9 мянган төгрөг болж өмнөх оноос 11920,0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд аж ахуйн материал 134494,1 мянган төгрөгөөс 146543,8 мянган төгрөг болж өссөн бөгөөд оны сүүлчээр ковид-19 цар тахалтай холбогдон нэг удаагийн ариутгал, хамгаалалтын зүйлс бэлтгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны өмнөх оны үлдэгдэл 279247,4 мянган төгрөг байсан бол тайлант оны эцэст 506285,4 мянган төгрөг болж 227037,9 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба тайлант хугацаанд Баянхонгор сумд баригдаж буй 960 хүүхдийн сургуулийн газрыг 163023,0 мянган төгрөгөөр, БСУГ-т нийлүүлэгдсэн пургон автомашин 33600,0 мянган төгрөгөөр хүлээн авсан нь гол нөлөө үзүүлж байна.



Засгийн газрын оролцоо дансны өмнөх оны үлдэгдэл 260917,0 мянган төгрөг байсан бол тайлант онд 423940,0 мянган төгрөг болж 163023,0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Баянхонгор аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх онд 2739377,9 мянган төгрөг байсан бол тайлант онд 2578562,5 мянган төгрөг болж 160815,5 мянган төгрөгөөр буюу 5,9 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт нь 2061887,1 мянган төгрөгөөс 2241496,9 мянган төгрөг болж 179609,8 мянган төгрөгөөр өссөн байна. Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө өмнөх онд 522474,1 мянган төгрөг байсан бол тайлант онд 27525,0 мянган төгрөг болж 494949,2 мянган төгрөгөөр буурсан нь гол нөлөө үзүүлж байна.

Нийт зардал өмнөх онд 2759580,3 мянган төгрөг байсан бол тайлант онд 2493005,7 мянган төгрөг болж 266574,6 мянган төгрөгөөр буюу 9,7 хувиар буурсан байна. Энэ нь тайлант хугацаанд цалингийн зардал өмнөх оноос 58554,9 мянга, бараа материал акталсны зардал /ном/ 85604,0 мянга, тэтгэвэр гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 80028,1 мянган төгрөгөөр өссөн бол бага үнэтэй түргэн элэгдэх зүйл 63288,9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг төлбөр хураамж 219639,7 мянга, Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 242676,0 мянган төгрөгөөр буурсан нь материаллаг дүнг эзэлж байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд үндсэн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 518354.0 мянган төгрөгөөр төсөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 130159,2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 648513,2 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүргүүлсэн саналаас гол нэмэгдэн батлагдсан зардал нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 239440,0 мянган төгрөг нэмж баталсан бол цалингийн зардлыг 41703,9 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 2394,7 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын 7185,4 мянган төгрөгөөр бууруулж, дотоод томилолтын 11832,0 мянга, хичээл практикийн зардлын 42350,0 мянган төгрөгийг хасаж баталжээ.

Харин оны дундуур бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрөөс 26640,2 мянга, Бараа үйлчилгээний бусад зардлаас 8628,8 мянган төгрөгийг хасаж цалингийн зардлаас 4000,0 мянга, хангамжийн материал 17383,7 мянган төгрөгөөр нэмсэн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн гүйцэтгэл



Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2241570,7 мянган төгрөгийн төсөв баталсныг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2241496,9 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 2186212,3 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 55284,6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2186212,3 мянган төгрөг буюу 97,5 хувьтай байгаа нь тэтгэвэрт гарах хүсэлт өгөөгүй байхад тэтгэмж төсөвт суулгасан, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан жилийг буруу тооцоолсноос шалтгаалж 54168,3 мянган төгрөгийн буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ	2,241,570,700.00	2,186,212,333.15	55,358,366.85	97.53
ХӨТӨЛБӨР 71801-Сургуулийн өмнөх боловсрол	433,580,000.00	424,014,852.00	9,565,148.00	97.79
АРГА ХЭМЖЭЭ 80802	433,580,000.00	424,014,852.00	9,565,148.00	97.79
Бусад урсгал шилжүүлэг	433,580,000.00	424,014,852.00	9,565,148.00	97.79
Тэтгэвэрт гарахад олгох тэтгэм	237,666,400.00	231,984,684.00	5,681,716.00	97.61
Хөдөө орон нутагт тогтвор суур	195,913,600.00	192,030,168.00	3,883,432.00	98.02
ХӨТӨЛБӨР 71802-Ерөнхий боловсрол	1,178,659,900.00	1,134,056,763.00	44,603,137.00	96.22
АРГА ХЭМЖЭЭ 80802	1,178,659,900.00	1,134,056,763.00	44,603,137.00	96.22
Бусад урсгал шилжүүлэг	1,178,659,900.00	1,134,056,763.00		96.22
Тэтгэвэрт гарахад олгох тэтгэм	582,003,700.00	549,459,985.00	32,543,715.00	94.41
Хөдөө орон нутагт тогтвор суур	596,656,200.00	584,596,778.00	12,059,422.00	97.98
ХӨТӨЛБӨР 71808-Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага	629,330,800.00	628,140,718.15	1,190,081.85	99.81
АРГА ХЭМЖЭЭ 80101				
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	624,883,600.00	623,693,518.15	1,190,081.85	99.81
УРСГАЛ ЗАРДАЛ	624,883,600.00	623,693,518.15	1,190,081.85	99.81
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	624,883,600.00	623,693,518.15	1,190,081.85	99.81
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	285,827,800.00	285,790,153.00	37,647.00	99.99
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,046,800.00	36,986,605.15	1,060,194.85	97.21
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,294,100.00	46,263,350.00	30,750.00	99.93
Хангамж, бараа материалын зардал	23,843,700.00	23,799,270.00	44,430.00	99.81
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	220,000,000.00	219,999,390.00	610.00	100.00
Урсгал засвар				
Бараа үйлчилгээний бусад зардал	10,871,200.00	10,854,750.00	16,450.00	99.85



Харуул, хамгаалалтын зардал 80219	3,742,200.00	3,742,200.00	-	
Бусад нийтлэг АҮТХураамж	3,742,200.00	3,742,200.00	-	100.00
Ажил олгогчоос олгох тэтгэмж, 80802				
Бусад урсгал шилжүүлэг	705,000.00	705,000.00	-	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шаг урам	705,000.00	705,000.00	-	100.00

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 7 төрлийн нийт 444082,9 мянган төгрөг орж ирсэн бөгөөд 422188,2 мянган төгрөгийг зарцуулан оны эцэст 21894,9 мянган төгрөг төвлөрүүлсэн байна. Дээрх 7 төрлийн санхүүжилтийг зориулалт тус бүрээр авч үзвэл:

мянган төгрөг

№	Зориулалт	Санхүүжсэн дүн	Зарцуулсан	Буцаан төвлөрүүлсэн
1	Төсөл хөтөлбөр	43656.6	43656.6	0
2	Төрийн албан хаагчдад орон сууц, хашаа байшин худалдан авахад олгосон санхүүгийн дэмжлэг	105,000.0	105,000.0	0
3	Насан туршийн боловсрол	30000	27260.5	2739.5
4	Хүүхэд харах үйлчилгээ	24188.9	5333.6	18855.3
5	Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн зөвлөн туслах, хяналт-шинжилгээ хийх зардал	2371.5	2371.5	0
6	сайн багш хөтөлбөр сургалтын төлбөр	1250	950	300
7	Багш нарын нэгдсэн сургалтын зардал	964.6	964.6	0
	Нийт	207431.6	185536.8	21894.8

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 120 мэдээлэл, хугацаа хоцроосон 31 мэдээлэл байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	8	3	0
2	Хагас жил	4	4	0	4	0
3	Улирал бүр	1	4	3	1	0
4	Сар бүр	3	36	33	3	0
5	Тухай бүр	8	96	76	20	0
6	Нийт	27	151	120	31	0



3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд цалингийн зардлаас түлшний үнийн хөнгөлөлт олгосон 2261,0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг 2020.05.28-нд барагдуулсан.

Мөн Боловсролын тухай хуулийн 43.1.4, 43.1.7-д заасан тэтгэмжийг төлөвлөхдөө бодитоор төлөвлөж, БСШУСЯ-наас баталсан жагсаалтын дагуу багш ажилчдад олгож байх Өндөр настны Тэтгэвэрт гарах өргөдлөө өгч хуульд заасан тэтгэмжээ авсан боловч үргэлжлүүлэн ажиллаж буй багш, ажиллагсдын ажлын байрыг хуулийн дагуу зарлаж асуудлыг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан шийдвэрлэх ба эсвэл хуулийн дагуу олгосон тэтгэмжийг буцаан төлүүлж хуулийн зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллах зөвлөмж өгснийг БСУГ-ын даргын 2020.05.03 өдрийн №81 тоот албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15829,0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 693,3 мянган төгрөгийн алдааг залруулж, 13135,7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 2000,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Бие бус хөрөнгийн дансанд 6 төрлийн программ хангамж байгаа бөгөөд үүнээс 4 нь элэгдлээрээ өртгөө нөхсөн ба харин эд хариуцагчийн асаруу программ элэгдлийн тооцоолсон бол 2020.04.25-нд орлогод авсан 5200,0 мянган төгрөгийн үнэ бүхий шалгалтын дүн засах программын ашиглах жилийг 5 жил гэж программд оруулсан боловч элэгдлийг зардлыг тооцоогүй байсныг аудитаар залруулав.

Шийдвэрлэсэн нь:

Санхүүгийн тайланд 5200,0 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийн зардлыг нөхөн тооцож бодуулан 693,3 мянган төгрөгийг элэгдлийн зардлаар хүлээн зөвшөөрч тайланд залруулсан

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Тайлант онд 2241570,7 сая төгрөг батлагдаж санхүүжилтийг бүрэн авч гүйцэтгэлээр 2186212,3 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 55284,6 мянган төгрөгийн төвлөрүүлсэн байна. Хичээлийн жилд түрээсийн сурах бичгийн тооцоог авч үзэхэд 80757,3 мянган төгрөг төвлөрөхөөс 67621,6 мянган төгрөг төвлөрч 13135,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн сурах бичгийн тооцоог гаргуулан 13135,7 мянган төгрөгийг холбогдох байгууллагаас авч төвлөрүүлэх албан шаардлага өгөв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 2 төрлийн зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Баянхонгор аймгийн хэмжээнд боловсролын салбарын хөрөнгө оруулалтаар хийх тоног төхөөрөмжийн 220,0 сая төгрөгийн төсвийг батлахдаа тус газрын төсөвт батлагдсан боловч Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөрт баталж байгаа нь Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчигдөх нөхцөл үүссэн тул ТЕЗ-ийн нэгтгэлд авч үзэх шаардлагатай.



4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

1.1. Илрүүлэлт:

Мөн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон Ерөнхий боловсролын сургуулийн 7 багш 144418,9 мянган төгрөгийн, сургуулийн өмнөх боловсролын 4 багш 95015,6 мянган төгрөгийн тэтгэмж авсан атлаа үргэлжлүүлж ажиллаж байна.

1.2. Эрсдэл:

Төрийн албаны хууль зөрчигдөх

1.3. Өгсөн зөвлөмж: Өндөр настны Тэтгэвэрт гарах өргөдлөө өгч хуульд заасан тэтгэмжээ авсан боловч үргэлжлүүлэн ажиллаж буй багш, ажиллагсдын ажлын байрыг хуулийн дагуу зарлаж асуудлыг 2021 оны 2-р улиралд багтаан шийдвэрлэх ба цаашид ажиллуулах нөхцөлд хуулийн дагуу олгосон тэтгэмжийг буцаан төсөвт төлүүлж хуулийн зөрчлийг арилгах арга хэмжээг авч ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

2. ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд насан туршийн боловсролын зардлаас 2000,0 мянган төгрөгөөр автомашины бэхэлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д заасан “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2. Эрсдэл:

Хууль журам зөрчигдөх

2.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулдаг байдлыг зогсоож, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах:

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.АЗБАЯР 2021.02.25

А.ЦЭЭНЯМ 2021.02.25

Б.МӨНХБАТ 2021.02.25



5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020 он	Аудитын нэр:	Баянхонгор аймгийн Боловсрол соёл урлагийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: БНА-2021/167/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Баянхонгор аймгийн Боловсрол соёл урлагийн газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бие бус хөрөнгийн дансанд 2020.04.25-нд орлогод авсан 5200,0 мянган төгрөгийн үнэ бүхий шалгалтын дүн засах программын ашиглах жилийг 5 жил гэж программд оруулсан боловч элэгдлийг зардлыг тооцоогүй	693,3	Санхүүгийн тайланд залруулав.	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ц.Энхтөр, Л.Оюунтуяа
2	Хичээлийн жилд түрээсийн сурах бичгийн тооцоог авч үзэхэд 80757,3 мянган төгрөг төвлөрөхөөс 67621,6 мянган төгрөг төвлөрч 13135,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.	13135,7	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ц.Энхтөр, Л.Оюунтуяа
3	Мөн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон Ерөнхий боловсролын сургуулийн 7 багш 144418,9 мянган төгрөгийн, сургуулийн өмнөх боловсролын 4 багш 95015,6 мянган төгрөгийн тэтгэмж авсан атлаа үргэлжлүүлж ажиллаж байна.	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ц.Энхтөр, Л.Оюунтуяа
4	Тайлант онд насан туршийн боловсролын зардлаас 2000,0 мянган төгрөгөөр автомашины бэхэлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д заасан "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.	2000,0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, Нягтлан бодогч	Ц.Энхтөр, Л.Оюунтуяа
ДҮН		15829,0			

- о О о -